



MONGOLIAN
RUGBY

МОНГОЛЫН РАГБИГИЙН ХОЛБОО-2017

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 он

АГУУЛГА

МОНГОЛЫН РАГБИГИЙН ХОЛБООНЫ 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

РАГБИГИЙН ХӨГЖИЛ

Хурал, зөвөлгөөнүүд

Азийн Рагбигийн Холбооны хагас жилийн хурлыг зохион байгууллаа
Дэлхийн Рагбигийн Холбооны жилийн эцсийн хуралд оролцлоо
Азийн Рагбигийн Холбооны жилийн эцсийн хуралд оролцлоо

Сургалтууд

Рагбигийн хүчний бэлтгэлийн сургалт
Рагби 15 төрлийн дасгалжуулагчийн 1,2-р шатны сургалт
Дэлхийн Рагбигийн Холбооны сургагч багш бэлтгэх сургалт
Рагбигийн спортын танилцуулга сургалтыг ЗХ-ий 084-р анги дээр явууллаа
Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Рагбид оролцох нь хөтөлбөрийн багш бэлтгэх сургалт
Сэлэнгэ аймгийн Баянгол сүм /Баруунхараа/-д Рагбид оролцох нь хөтөлбөрийн багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа

ТЭМЦЭЭН УРАЛДААН

Улаанбаатар хотын цасны Точ рагбигийн цомын аварга шалгаруулах тэмцээн
Цасны рагби 2017 АШТ
ЕБС-иудын ӨАШТ 2017
Хартфорд коллежийн аялан тоглолт 2017-г зохион байгууллаа
Рагби 7 УАШТ-ийг 5 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа
Рагби 15 УАШТ-ийг амжилттай зохион байгууллаа

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хандивын арга хэмжээ зохион байгууллаа
Рагбид оролцох нь хөтөлбөрт ЕБС-иудыг дахин хамрууллаа
Асрамжийн газруудад Рагбид оролцох нь хөтөлбөрийг хэрэгжүүллээ
Их Британий элчин сайдын яамнаас зохион байгуулсан “Inspire me 2017” арга хэмжээнд рагбигийн спортыг танилцууллаа
Улаанбаатарын Олон Улсын Сургуультай хамтран рагбигийн хичээлийг зааж эхэллээ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД

РАГБИГИЙН ХӨГЖИЛ

Хурал, зөвөлгөөнүүд

Азийн Рагбигийн Холбооны хагас жилийн хурлыг зохион байгууллаа

Монголын Рагбигийн Холбоо Азийн Рагбигийн Хагас жилийн хурлыг Улаанбаатарт 2017 оны 5-р сарын 19-21-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Жилдээ 2 удаа Азийн Рагбигийн 28 гишүүн орны төлөөллүүд хуралдаж Ази тивийн рагбигийн бодлого, зорилго, зорилтуудыг тодорхойлох, тодотгол хийх, гишүүн орнуудын хөгжлийг авч хэлэлцэх гэх мэт олон асуудлыг авч шийдвэрлэдэг билээ. Үүний дагуу анх удаагаа Монгол оронд Азийн Рагбигийн хурлыг өндөр түвшинд маш амжилттай зохион байгуулж чадлаа.



Зураг 1. Азийн Рагбигийн Холбооны хурлын төлөөлөгчид

Энэхүү хурлын үеэр Азийн рагбигийн хөгжлөөс гадна Монголын рагбигийн гадаад бодлогын дэвшилтүүд, амжилт бүтээлүүдийг дүгнэн хэлэлцэж цаашид хөгжүүлэх чиглэлүүдийг мөн тодорхой авч хэлэлцсэнээрээ онцлог болов. Ялангуяа 2019 Рагбигийн Дэлхийн Аварга Шалгаруулах тэмцээн Япон улсад зохиогдох мөн 2020 Олимпын Наадам мөн л Япон улсад зохиогдохтой холбоотойгоор Японы рагбигийн холбоо рагбиг цаашид Ази тивд өргөжүүлэн хөгжүүлэхэд Монголын Рагбигийн Холбоотой хамтран ажиллах боломжтойг мэдэгдсэн билээ.



Зураг 2. Дэлхийн Рагбигийн Холбооны эмэгтэй рагбигийн Ерөнхий менежер Катерэйн

2023 оны Дэлхийн Аварга Шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахаар өрсөлдөж буй орнуудын төлөөллүүд болох Ирланд, Өмнөд Африк болон Францын Рагбигийн Холбооны хамгийн дээд удирдагчид мөн хүрэлцэн ирж энэхүү хурлын ач холбогдолыг улам өсгөсөн билээ.



Зураг 3. Ирланд улсын Рагбигийн Холбооны удирдагчид



Зураг 4. Франц улсын Рагбигийн Холбооны удирдлагууд



Зураг 5. Өмнөд Африк улсын Рагбигийн Холбооны удирдлагууд

Цаашид МРХ нь үр чадвартай багш дасгалжуулагч, шүүгч, эмч нар бэлдэхээс гадна олон улсын тэмцээн уралдааны тоог нэмэгдүүлэн мөн чанартай тэмцээн уралдаанд тогтмол оролцож, шилдэг тамирчдыг бэлтгэн гаргаж, Ази тивдээ тэргүүлэх рагбигийн гүрнүүдийн нэг болохоор зорин ажиллаж байна.

Хурлын үеэр бид бүхнийг дэмжиж хамтран ажилласан спонсор байгууллагууд болох ЖЕМ Интернэшнл ХХК, Эм Ай Си Си ХХК мөн мэргэжлийн сайн үйлчилгээ үзүүлсэн Корпорейт зочид буудалд талархсанаа илэрхийлье.



Зураг 6. Хурлын үеэр



Зураг 7. Казакстаны Рагбигийн Холбоо гишүүнчлэлээ сэргээлээ

Дэлхийн Рагбигийн Холбоо болон Азийн Рагбигийн Холбооны жилийн эцсийн хуралд оролцлоо

2017 оны 11 сарын 13-14-ний хооронд Англи улсын Лондон хотноо болсон Дэлхийн Рагбигийн Холбооны жилийн эцсийн хурал, мөн 2017 оны 11 сарын 18-19-ний ххоронд Хонг Конгод болсон Азийн Рагбигийн Холбооны хуралд Монголын Рагбигийн Холбооны Гүйцэтгэх захирал Г.Дашдэндэв оролцож Монголын Рагбигийн хөгжлийг танилцуулсан бөгөөд ирэх жилүүдэд рагбигийн спортоор тэргүүлэх улс орнуудтай хамтран ажиллах, тамирчин солилцоо, техник хэрэгслийг нэмэгдүүлэх ажлуудыг хамтран ажиллаж хийхээр болсныг дуулгаж байна.



Зураг 8. Дэлхийн Рагбигийн Холбооны 2017 оны жилийн эцсийн хурал

Тус хурлын үеэр 2023 оны Рагбигийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах улсыг сонгох сонгуульд Өмнөд Африк, Ирланд, Франц гэсэн 3 улс өрсөлдөж Франц улс зохион байгуулах эрхийг авсан юм.



Зураг 9. Азийн Рагбигийн Холбооны жилийн эцсийн хурал

Сургалтууд

Рагбигийн хүчний бэлтгэлийн сургалт

Рагбигийн хүчний бэлтгэлийг хэрхэн хийх, хэрхэн рагбид бэлдэх вэ? Сургалтыг Хан-Уул рагби клубын баг тамирчдад Монголын Рагбигийн Холбооны Гүйцэтгэх захирал, Дэлхийн Рагбигийн Холбооны сургагч багш Г.Дашдэндэв удирдан амжилттай зохион байгууллаа.



Зураг 10. Сургалтанд хамрагдсан багш тамирчид



Зураг 11 .Тэнцвэрийн дасгал



Зураг 12.Булчингийн чангарлын шалгалт

Рагби 15 төрлийн дасгалжуулагчийн 1,2-р шатны сургалт

Дэлхийн Рагбигийн Холбооны багш, дасгалжуулагч сургагч Рамбо Лиунг болон Монголын Рагбигийн Холбооноос хамтран сонгон шалгаруулсан 7 оролцогчдод 2017 оны 5 сарын 26-28-ны өдрүүдэд дасгалжуулагчийн 1 болон 2-р шатны сургалтыг амжилттай зохион байгууллаа. Тус сургалтыг МҮОХ-ны хурлын байр болон Монголын Үндэсний Бейсбол, Софтболын Холбоо дэмжин сургалт зохион байгуулах сургалт бэлтгэлийн талбайгаар хангаж өгсөн юм.



Зураг 13. Сургалтанд оролцсон дасгалжуулагчид

Энэхүү сургалт нь хүндрүүлсэн шатны сургалт бөгөөд оролцогч нарт онол практик хослуулсан өндөр өгөөжтэй сургалт болсон юм. Сургалтыг монгол улсдаа зохион байгуулж байгаа нь зардал мөнгийг хэмнэх төдийгүй ирээдүйн рагбигийн баг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх, шинэ шатанд гарахад багш дасгалжуулагчдыг бэлтгэх нь туйлын ач холбогдолтой юм.

Дасгалжуулагчийн 1 болон 2-р шатны сургалтанд дараах оролцогч нар хамрагдлаа:

1. Б.Мандах /Анхдагч Чононууд РК/
2. Е.Бямбабүтэд /Ангууч Арслангууд РК/
3. Б.Дэлгэрмаа /Хан-Уул РК/
4. Б.Наранбаатар /Хан-Уул РК/
5. Г.Балгансүрэн /Анхдагч Чононууд РК/
6. М.Цогт-Эрдэнэ /Аварга Зөгийнүүд РК/
7. Ц.Зулаа /Хөх Толбот Дайчид РК/
8. Б.Солонготуяа /Хөх Толбот Дайчид РК/
9. Н.Батаа /Хан-Уул РК/

Дэлхийн Рагбигийн Холбооны сургагч багш бэлтгэх сургалт

Өнгөрсөн онд Хонг Конгод зохиогдсон Дэлхийн Рагбигийн Холбооны сургагч багш бэлтгэх сургалтанд Монголын Рагбигийн Холбооны Гүйцэтгэх захирал Г.Дашдэндэв болон дасгалжуулагч Н.Энх-Амгалан нар хамрагдсан бөгөөд Гүйцэтгэх захирал Г.Дашдэндэв Монголын анхны Дэлхийн Рагбигийн Холбооны шүүгчдийг бэлтгэх эрхтэй сургагч багш болсон билээ. Харин дасгалжуулагч Н.Энх-Амгалан Дэлхийн Рагбигийн Холбооны сургагч багштай хамтран зохион байгуулж, тодорхой шалгалтанд хамрагдаж сургагч багш болох эрхтэй болсон юм.

Энэ удаагийн сургалтыг Монголын Рагбигийн Холбооны дасгалжуулагч Н.Энх-Амгалан Дэлхийн Рагбигийн Холбооны багш, дасгалжуулагч сургагч Рамбо Лиунгийн хамт удирдан явуулж Дэлхийн Рагбигийн Холбооны 1-р шатны дасгалжуулагч бэлтгэх эрхтэй сургагч багш болох болзлоо хангаж чадсаныг дуулгахад таатай байна.



Зураг 14. Дасгалжуулагч нарын дадлагын цаг



Зураг 15. Дасгалжуулагч нарын дадлагын цаг

Рагбигийн спортын танилцуулга сургалтыг ЗХ-ий 084-р анги дээр явууллаа

Монголын Рагбигийн Холбоо нь 2016 онд Батлан Хамгаалах Яамтай хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд Алдар Спорт хороотой хамтын ажиллагааны санамж бичигт гарын зурсантай холбогдуулан 2017 оны 8 дугаар сарын 11-нд Зэвсэгт Хүчний 084-р ангийн 110 алба хаагчдад рагбигийн спортын танилцуулга сургалтыг зохион байгуулсан. Энэхүү сургалтанд хамрагдсан алба хаагчид ирэх оны Зэвсэгт Хүчний Жанжин Штабын Орлогч дарга, Хошууч генерал Ж.Бадамбазарын 2016 оны 09 дүгээр сарын 13-ны А/390 тоот тушаалаар батлагдсан “Зэвсэгт хүчний аварга шалгаруулах Рагби 7 тэмцээн”-д баг бүрдүүлэн оролцох юм.



Зураг 16. Зэвсэгт Хүчний 084-р ангийн бие бүрэлдэхүүн



Зураг 17. Сургалтын үеэр

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Рагбид оролцох нь хөтөлбөрийн багш бэлтгэх сургалт

Монголын Рагбигийн Холбоо нь 2016 оноос эхлэн Монголын Зуслангуудын Холбоотой хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, зуслангуудад Дэлхийн Рагбигийн Холбооны “Рагбид оролцох нь хөтөлбөр”-ийг ажилттай хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Энэ онд хоёр дахь жилдээ тус хөтөлбөрийг нийслэл хотод ойр байрлах зуны 10 зусланд хэрэгжүүлж, хүүхэд багачуудад рагбигийн спортыг таниулан сурталчиллаа.



Зураг 18. Найрамдал Цогцолборын багш нар

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын Рагбид оролцох нь хөтөлбөрийн багш бэлтгэх сургалтыг зохион байгуулж, нийт 11 багшийг амжилттай хамрууллаа.



Зураг 19. Дадлагын цаг

Сэлэнгэ аймгийн Баянгол сум /Баруунхараа/-д Рагбид оролцох нь хөтөлбөрийн багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа

Сэлэнгэ аймгийн Баянгол сум буюу Баруунхараад Рагбид оролцох нь хөтөлбөр амжилттай зохион байгуулагдлаа. Хөтөлбөрийн эхний өдөр дасгалжуулагч бэлтгэх сургалт болсон бөгөөд нийт 7 багш амжилттай хамрагдаж Рагбид оролцох нь хөтөлбөрийг заах эрхтэй дасгалжуулагч болсон юм.

Хөтөлбөрийн хоёр дахь өдөр дасгалжуулагчид Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Улсын Тэргүүний Бүрэн дунд сургуулийн эрэгтэй 30, эмэгтэй 10 сурагчдад сургалтаа хийсэн.



Зураг 20. Хөтөлбөрт хамрагдсан багш нар болон хүүхэд багачууд

Энэхүү арга хэмжээг зохион байгуулах саналыг гарган биднийг урьж хамтран ажилласан Rich River Care Center ТББ-ын хамт олондоо баярлалаа.



Зураг 21. Сурагчид бэлтгэлд хамрагдлаа



Зураг 22. Багш нар Гэрчилгээгээ авлаа

ТЭМЦЭЭН УРАЛДААН

Улаанбаатар хотын цасны Точ рагбигийн цомын аварга шалгаруулах тэмцээн



Зураг 23. Тэмцээний сурталчилгаа

Монголын Рагбигийн Холбоо нь Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Нийслэлийн Аялал Жуулчлалын Газар-т хамтран ажиллах хүсэлт гаргасан бөгөөд энэхүү хүсэлтийг хүлээн авч, монгол улсад шинэ тутам хөгжиж буй багийн спортыг дэмжин “Улаанбаатарын өвлийн наадам-2017”-д анх удаагаа албан ёсоор оролцуулахаар болсон билээ.

“Улаанбаатарын өвлийн наадам” нь өвлийн болон түсгай аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлыг уртасгах зорилготой тус арга хэмжээнд рагбигийн спортыг анх удаагаа амжилттай танилцуулж, Улаанбаатар хотын цасны Точ рагбигийн цомын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсанаар Монголын Рагбигийн Холбооны улирлыг уртасгаж, тамирчдын бэлтгэлжилтийг нэмэгдүүлэхэд өндөр ач холбогдол өгсөн наадам болсон юм.

“Улаанбаатарын өвлийн наадам-2017” наадамд Монголын Рагбигийн Холбооны харъяа 8 клубын эрэгтэй, эмэгтэй холимог 8 баг мэдүүлгээ өгч оролцсон юм. Тэмцээний багууд 2 бүсэд хуваагдаж тойргийн системээр тоглож, бүсээсээ шалгарсан багууд цомын төлөө өрсөлдөн аваргуудаа шалгаруулсан юм.



УЛААНБААТАРЫН ӨВЛИЙН НААДАМ-2017

ГЭР БҮЛИЙН БАЯР



Зураг 24. Рагбигийн спортын цол хүртсэн тамирчид МРХ-ны удирдлагуудын хамт

“Улаанбаатарын өвлийн наадам-2017” наадмын үеэр Монголын Рагбигийн Холбооны рагбигийн спортын цол зэрэг хүртсэн тамирчдад цол зэргийг гардуулсан юм. ОУХМастер цолоор 2 тамирчин, спортын мастер цолоор 9 тамирчин, спортын дэд мастер цолоор 4 тамирчин хүртэж, энгэрээ мялаасан юм.



Зураг 25. Тэмцээний нээлтийн ажиллагаа

Тэмцээний үеэр үзэгч наадамчдын дунд рагбигийн спортын хөгжөөнт уралдаант тэмцээнийг зохион байгуулж, мөн тэмцээнд оролцохыг хүссэн наадамчид рагбигийн багт орж цасны рагбигийн тэмцээнд оролцож, нэгэн өдрийг хөгжилдөн өнгөрүүлсэн билээ.



Зураг 26. Үзэгч, наадамчид бөмбөг дамжуулах тэмцээнд оролцож байгаа нь



Зураг 27. Тоглолтын үеэр



Зураг 28. Бүсийн тоглолтууд үргэлжилсээр

**Улаанбаатар хотын Цасны Рагбигийн 2017 оны
Аварга Шалгаруулах Тэмцээний Бүсийн тоглолтын үр дүн
/2016 оны 2 дугаар сарын 11/**

№	Цаг	Тоглох багууд		Төрөл	Бүс	Ерөнхий дүн	
Нээлт, багуудын бүртгэл							
1	1300	Анхдагч Чононууд	Ирвэсүүд	Холимог баг	А	10	0
2	1315	Ангууч Арслангууд	Хөх Толбот Дайчид	Холимог баг	В	0	10
3	1330	Блуз	Хан-Уул	Холимог баг	А	0	15
4	1345	Аварга Зөгийнүүд	Грийнс	Холимог баг	В	10	0
5	1400	Хан-Уул	Анхдагч Чононууд	Холимог баг	А	17	5
6	1415	Грийнс	Ангууч Арслангууд	Холимог баг	В	0	12
Хөгжөөнт тэмцээн							
7	1430	Блуз	Анхдагч Чононууд	Холимог баг	А	7	22
8	1445	Аварга Зөгийнүүд	Хөх Толбот Дайчид	Холимог баг	В	5	15
9	1500	Ирвэсүүд	Хан-Уул	Холимог баг	А	5	7
10	1515	Хөх Толбот Дайчид	Грийнс	Холимог баг	В	20	0
11	1530	Блуз	Ирвэсүүд	Холимог	А	5	5

				баг			
12	1545	Аварга Зөгийнүүд	Ангууч Арслангууд	Холимог баг	В	5	5
Интертайммент цаг							

Хүснэгт 1

**Улаанбаатар хотын Цасны Рагбигийн 2017 оны
Аварга Шалгаруулах Тэмцээний Бүсийн тоглолтын үр дүн
/2016 оны 2 дугаар сарын 12/**

№	Цаг	Тоглох багууд		Төрөл	Ерөнхий дүн	
Нээлт, багуудын бүртгэл						
1	1200	Блуз	Грийнс	Холимог баг	10	5
2	1215	Ирвэсүүд	Ангууч Арслангууд	Холимог баг	0	12
3	1230	Анхдагч чононууд	Хөх Толбот Дайчид	Холимог баг	0	17
4	1245	Аварга Зөгийнүүд	Хан-Уул	Холимог баг	5	10
Хөгжөөнт тэмцээн						
5	1315	Грийнс	Ирвэсүүд	7-р байрны төлөөх тоглолт	0	5
6	1330	Ангууч Арслангууд	Блуз	5-р байрны төлөөх тоглолт	19	0
7	1345	Анхдагч Чононууд	Аварга Зөгийнүүд	Хүрэл медалийн төлөөх тоглолт	12	0
8	1400	Хан-Уул	Хөх Толбот Дайчид	Алтан медалийн төлөөх тоглолт	5	0
Интертайммент цаг						

Хүснэгт 2

Улаанбаатар хотын цасны Точ рагбигийн цомын аварга шалгаруулах анхдугаар тэмцээний хүрэл медалийг Анхдагч Чононууд РК, мөнгөн медалийг Хөх Толбот Дайчид РК, тэмцээний алтан медаль болон цомын эзнээр Хан-Уул РК шалгарлаа.

“Улаанбаатарын өвлийн наадам”-ын Улаанбаатар хотын цасны Точ рагбигийн цомын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Нийслэлийн Аялал Жуулчлалын Газар, Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэнгийн нийт хамт олонд талархал илэрхийлж байна.

Цасны рагби 2017 АШТ

Цасны Рагби 2017 УАШТ 3 долоо хоногийн түрш амжилттай үргэлжилж, аваргуудаа шалгарууллаа. Тэмцээнийг зохион байгуулахад тусалсан Төв Цэнгэлдэх Хүрээлэнгийн нийт хамт олонд болон МРХ-ны харьяа рагби клубүүдийн нийт баг тамирчдад талархал илэрхийлье.



Зураг 29. Хан-Уул РК-Холимог багийн эсрэг

Цасны Рагби 2017 УАШТ-ий эмэгтэй багийн 4 дүгээр байрт Хөх Толбот Дайчид болон Ангууч Арслангууд РК-ын нэгдсэн баг орсон бол хүрэл медалийг Аварга Зөгийнүүд РК, мөнгөн медалийг Анхдагч Чононууд РК, аваргын алтан медаль, цомын эзнээр Хан-Уул РК тодорлоо.



Зураг 30. Анхдагч Чононууд РК-Аварга Зөгийнүүд РК

Цасны Рагби 2017 УАШТ-ий эрэгтэй багийн 6 дугаар байрт Ирвэсүүд РК, 5 байр буюу Аяган цомны эзнээр Аварга Зөгийнүүд РК, 4 байрт Анхдагч Чононууд РК, хүрэл медаль, тавган цомыг Ангууч Арслангууд РК, мөнгөн медалийг Хан-уул РК, аваргын алтан медаль, цомын эзнээр Хөх Толбот Дайчид РК шалгарлаа.

Мөн тэмцээний шагнал гардуулах ёслолын ажиллагааны үеэр Халуун сэтгэл in Japan ТББ-аас "Дулаан өвөлжье" аяны хүрээнд Японы рагби клубын хамт олон, иргэдээс ирүүлсэн хандивын рагбигийн хувцас хэрэглэлийг тэмцээнд оролцсон баг тамирчдад гардуулж өгсөн юм.



Зураг 31. Тэмцээний хаалтын ажиллагаа



Зураг 32. Шагнал гардуулах ёслолын ажиллагаа

ЕБС-иудын ӨАШТ 2017

Монголын Рагбигийн Холбооноос 8 дахь жилдээ зохион байгуулагдсан нийслэлийн ерөнхий боловсролын 8 сургуулийн эрэгтэй 8 баг, эмэгтэй 4 багийн 200 гаруй өсвөрийн тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа сорин үзэж шилдгүүдээ тодруулсан билээ.

Тэмцээний эмэгтэй баг тамирчид Олимпийн төрөлд багтсан Рагби 7 төрлөөр өрсөлдөж 1-р байрыг Ирээдүй цогцолбор сургууль, 2-р байрыг Хан-Уул РК, 3-р байрыг Амгалан цогцолбор сургууль тус тус эзэллээ. Эрэгтэй баг тамирчид Рагби 10 төрлөөр өрсөлдөж 1-р байрыг Аварга лицей сургууль, 2-р байрыг Техник технологийн коллеж, 3-р байрыг Аварга лицей сургуулийн 2-р баг шалгарлаа. Тэмцээний шилдэг эрэгтэй тамирчнаар Аварга лицей сургуулийн О.Билэгт, эмэгтэй тамирчнаар Ирээдүй цогцолбор сургуулийн П.Халиун нар тодорсон юм.

Тэмцээний онцлогийг дурдвал тэмцээнд оролцсон хөвгүүдийн багуудын шилдэг тамирчдаас Өсвөрийн шигшээ багийг бүрдүүлэн 7 сарын 22-29-ний өдрүүдэд зохиогдох БНХАУ-ын 19-наас доош шигшээ багийн эсрэг тоглолтонд рагби 15 төрөлд өрсөлдөх багийг сонгон шалгаруулсан болно.



Зураг 33. ӨАШТ 2017-д оролцсон баг тамирчид

2017 оны ЕБС-иудын тэмцээнийг Нийслэлийн Боловсролын Газар дэмжлэг үзүүлэн хамтран зохион байгуулсан бол тэмцээнд байр эзэлсэн багуудад өргөмжлөл, шилжин явах цом, медал, мөнгөн шагналыг гардуулж шинэ залуу тамирчдаа урамшуулан дэмжсэн ААН байгууллага, хувь хүмүүстээ талархсанаа илэрхийлье.

ХАРТФОРД КОЛЛЕЖИЙН РАГБИ КЛУБЫН АЯЛАН ТОГЛОЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН



Hertford College

Монголын Рагбигийн Холбоо нь Англи улсын Оксфордын Их Сургуулийн Хартфорд коллежтой хамтын ажиллагаатай бөгөөд 2013 оноос эхлэн Хартфорд коллежийн рагбигийн багийн аялан тоглолтыг эх орондоо хүлээн авч “Рагби Фестивал 2013” наадмыг амжилттай зохион байгуулсан билээ.



Зураг 34. Улаанбаатарын Дайчид рагби клуб – Хартфорд коллежийн рагби клубүүдийн нэгдэх тоглолт

Үүнээс хойш 4 жилийн дараа буюу 2017 онд дахин Хартфорд коллежийн рагбигийн багийг хүлээн авч, Улаанбаатарын Дайчид рагби клубтэй 2 гол тоглолтыг Монголын Бейсбол, Софтболын Үндэсний Холбооны талбайд 2 өдрийн хөтөлбөртэйгөөр буюу 2017 оны Долдугаар сарын 22, Долдугаар сарын 28-ны өдрүүдэд тус наадмыг зохион байгууллаа.

Энэхүү арга хэмжээ нь монголын спорт сонирхогчдод Рагбигийн спорт, түүний үзэл санааг таниулан сурталчлах мөн түүнчлэн энэхүү спортоор хичээллэгч, тамирчдад туршлага хуримтлуулахад гол зорилгоо болгосон юм.

2017 оны Долдугаар сарын 22-ны өдөр Улаанбаатарын Дайчид рагби клубын залуу тамирчдаас бүрдсэн баг Хартфордын коллежийн рагбигийн багийн эсрэг тоглосон юм.



Зураг 35.Лайн-Аут

Улаанбаатарын Дайчид рагби клубын залуучуудын багийн бэлтгэл 2017 оны 6 дугаар сараас эхэлсэн бөгөөд энэ үеэс баг тамирчдыг сонгон шалгаруулж бэлтгэсэн юм.

Хартфорд коллежийн рагбигийн багийн эсрэг тоглолтонд тоглосон Улаанбаатарын Дайчид рагбигийн багт урьд өмнө шигшээ баг болон түс багт тоглож байгаагүй шинэ залуу тамирчдад боломж олгон, залгамж халаагаа бэлтгэн тэдэнд туршлага хуримтлуулахад гол зорилгоо болгосон билээ.



Зураг 36.Тоглолтын үргэлжилж байна

Улаанбаатарын Дайчид болон Хартфорд коллежийн рагбигийн багуудын тоглолт 16:00 цагт Бейсболын талбайд эхэлсэн бөгөөд тоглолтын нэгдүгээр үеэс өрсөлдөөнтэй гал гарсан тоглолтоор үргэлжлэн Хартфорд коллежийн рагбигийн багийн тоглогч эхний оноог авсан.



Зураг 37. Хартфорд коллеж болон Улаанбаатарын Дайчид рагби клубын тоглолт

Тоглолтыг оноо авалтаар эхлүүлсэн Хартфорд багийн тамирчдын арын эгнээний довтолгоонууд амжилттай болж ээлж дараалан оноог авч тооны харьцааг холдуулж эхэлсэн ч Улаанбаатарын Дайчид багийн үрд эгнээний тамирчдын довтолгоо болон хамгаалалтууд хүчтэй болсноор онооны зөрүүг ойртуулж чадсан юм.

Тоглолтын нэгдүгээр үеийг Хартфорд коллежийн багийн давамгайллаар өндөрлөсөн бол хоёрдугаар үед Улаанбаатарын Дайчид баг сэлгээ хийж түршлагатай тамирчдаа тоглуулсан болов ч тоглолтын тоог нөхөж амжаагүй тоглолтын тооны харьцаа 17-27 гэсэн харьцаатайгаар Английн Оксфордын Хартфорд коллежийн рагбигийн баг тамирчид 2017 оны аялан тоглолтынхоо анхны хожлыг авч, олон улсын их дээд сургуулиудын дунд зохион байгуулагдаж байгаа хоёрдугаар тэмцээнийг ийнхүү эхлүүлсэн билээ.



Зураг 38. Лайн-Аут



Зураг 39 .Хартфорд коллежийн рагбигийн багийн довтолгоо



Зураг 40. Улаанбаатарын Дайчид 17 – 27 Хартфорд коллеж рагби

Хартфорд коллежийн рагбигийн багийн залуус “Эрдэм төв”-д зочиллоо

Хартфорд коллежийн рагбигийн багийн залуу тамирчид Сонгинохайрхан дүүргийн хүүхдийн “Эрдэм төв”-д зочилж тус төвийн үйл ажиллагаатай танилцаж, хүүхэд багачуудтай тоглож нэгэн өдрийг өнгөрүүлсэн билээ.



Зураг 41. Хартфорд коллежийн рагбигийн багийн тамирчид хүүхдүүдтэй рагби тоглолоо

Хартфорд коллежийн рагбигийн багийн залуус маань бяцхан хүүхэд багачуудад гарын бэлэг бэлдэж тэднийг сурч боловсроход нь хэрэгтэй тоглоомуудыг гардуулан өгч хамтдаа рагби, сагсан бөмбөг, хөзөр, зураг зурж хүүхэд багачуудыг баярлуулсан юм.

Мөн Хартфорд коллежийн рагбигийн багийн менежер Жон Коллинс төвийн дотуур байртай танилцаж хүүхэд багачуудад өвлийн улирлыг дулаан өнгөрүүлэхэд анхаарч өвөл дулаан хувцас өгөхөө мэдэгдсэн юм.



Зураг 42. Хүүхэд багачуудтай цагийг хөгжилтэй өнгөрүүллээ



Зураг 43. Хүүхэд багачуудад гарын бэлэг гардууллаа



Зураг 44. Зураг 41 Хүүхэд багачууд болон тамирчид



Зураг 45. Хүүхэд багачууд болон тамирчид

Улаанбаатарын Дайчид рагби клуб – Хартфорд коллежийн рагби клубүүдийн хоёр дахь тоглолт



Hertford College

Улаанбаатарын Дайчид рагби клуб – Хартфорд коллежийн рагби клубүүдийн хоёр дахь тоглолт Долдугаар сарын 28-ны Баасан гарагт 17:00 цагт эхэлсэн. Улаанбаатарын Дайчид рагби багт Монголын Рагбигийн Холбооны харьяа 6 клубын тамирчдаас багаа бүрдүүлсэн юм.



Зураг 46. Нээлтийн ажиллагаа

Тоглолт Улаанбаатарын Дайчид рагби багийн хүчтэй довтолгоонуудаар тоглолтыг удирдаж эхэлсэн ба Хартфорд коллежийн рагбигийн багийн тамирчин алдааг хожиж торгуулийн өшиглөлтийг амжилттай хийж тоглолтын анхны оноог авсан бол удалгүй Улаанбаатарын Дайчид рагби багийн зүүн жигүүрээр хийсэн хурдан довтолгоогоор Трай авч тоглолтыг Улаанбаатарын Дайчид рагби клуб хошуучилсан юм.

Улаанбаатарын Дайчид рагбигийн баг тамирчид хүчтэй довтолгоог хийн тоглолтын дараа дараагийн Трайг авч илт хошуучилж 17 – 8 гэсэн оноотойгоор ялж байсан бөгөөд Хартфорд коллежийн рагбигийн багийн тоглогч бөмбөгийг хоёр удаа таслан хоёр трайг ээлжлэн авч тоглолтын тооны харьцааг 17 – 18 гэсэн нэг онооны зөрүүтэйгээр хоёр дахь тоглолтонд ялалт байгуулсан билээ.



Зураг 47. Улаанбаатарын Дайчид Лайн-Аутыг хожлоо



Зураг 48. Урд эгнээний довтолгоо үргэлжилсээр



Зураг 49. Лайн-аутыг амилттай хамгааллаа



Зураг 50. Тоглолтын скрамыг Улаанбаатарын Дайчид баг тун хүчтэйгээр түрж байгаа нь

Рагби 7 төрлийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг 5 дахь жилдээ зохион байгууллаа

Олимпийн төрөл болох Рагби 7 төрлийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2013 оноос хойш 5 дахь жилдээ зохион байгуулж 2017 оны 9 дүгээр сарын 2-нд шилдгүүдээ шалгаруулсан.

Тус тэмцээнд эрэгтэй 6 баг, эмэгтэй 3 багийн 150 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс эмэгтэй төрөлд Хан-Уул рагби клубын эмэгтэй баг хүрэл медаль, Хөх Толбот Дайчид рагби клубын эмэгтэй баг мөнгөн медаль, аваргын алтан медаль цомын эзнээр Анхдагч Чононууд рагби клубын эмэгтэй баг шалгарсан билээ.

Тэмцээний эрэгтэй төрөлд Аварга Зөгийнүүд рагби клуб 6 дугаар байр, Ирвэсүүд рагби клуб 5 дугаар байр, Хөх Толбод Дайчид рагби клуб 4 дүгээр байр, Анхдагч Чононууд рагби клуб хүрэл медаль, Хан-Уул рагби клуб мөнгөн медаль, Ангууч Арслангууд рагби клуб алтан медаль, аваргын цомын эзэн болж 5 удаагийн аварга болж үнэмлэхүй рекордыг Монголын рагбигийн түүхэнд байгуулаад байна.



Зураг 51. Рагби 7 УАШТ-нд оролцсон нийт баг тамирчид



Зураг 52. Рагби 7 төрлийн 5 удаагийн аварга Ангууч Арслангууд рагби клуб

Рагби 15 төрлийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг амжилттай зохион байгуулж аваргуудаа тодрууллаа

Рагби 15 төрлийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2013 оноос хойш 5 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд тус тэмцээнд оролцох баг болон тамирчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа билээ.

Тус тэмцээнд эрэгтэй 5 баг нийт 5 долоо хоногийн турш багийн ажиллагаа, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж нийлбэр оноог цуглуулсан бөгөөд Ангууч Арслангууд рагби клуб нийлбэр оноо 2-г авч 5 дугаар байр, Аварга Зөгийнүүд рагби клуб нийлбэр оноо 5-г авч чадсанаар 4 дүгээр байрт шалгарсан юм. Харин тэмцээний тэргүүн байрын төлөө 3 клуб тус бүр нийлбэр 15 оноотой дуусгасан ба тэмцээний турш авсан онооны зөрүүгээр байр эзлүүлсэн билээ. Ингээд Хан-Уул рагби клуб хүрэл медаль, Хөх Толбот Дайчид рагби клуб мөнгөн медаль, аваргын алтан медаль, цомын эзнээр Анхдагч Чононууд рагби клуб тодорч Монголын Рагбигийн Холбооны Рагби 15 төрөлд хошой аварга болж чадсан.



Зураг 53. Рагби 15 УАШТ



Зураг 54. Ангууч Арслангууд рагби клубын довтолгоо



Зураг 55. Скрам



Зураг 56. Лайн-Аут буюу хажуугийн шаугамаас бөмбөгийг тоглолтонд оруулж байна

Хандивын арга хэмжээ зохион байгууллаа



Зураг 57. Хандивын арга хэмжээнд оролцсон зочин оролцогчид

Монголын Рагбигийн Холбоо нь үйл ажиллагаагаа олон нийтэд таниулах болон аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах, хүрээгээ тэлэх зорилготойгоор Хандивын арга хэмжээг зохион байгуулсан. Монгол улсын Рагбигийн шигшээ багийн тамирчин байсан Монгол улсын Арслан До.Ганхуяг, Австралийн Рагбигийн Холбооны шүүгч Грэг Хинтон болон Монголын улсын Рагбигийн шигшээ багийн тамирчин Холимог тулааны спортын тулаанч Х.Амартүвшин нар зочин оролцогчоор оролцож рагбигийн спортын онцлог давуу талууд зэрэг сонирхолтой хөгжилтэй яриаг ивээн тэтгэгч байгууллагууд, хөгжөөн дэмжигч хувь хүмүүст дэлгэсэн юм.



MONGOLIAN RUGBY FOOTBALL UNION

FUNDRAISING DINNER

ALL PROCEEDS TO ASSIST RUGBY

SATURDAY
APR 22

GUEST SPEAKERS



Mongolian National Wrester
"Lion", Former Rugby Player
Mr. GANKHUYAG DORJPALAM



Former Australian Rugby
Referee Mr. GREG HINTON



Mixed Martial Artist, Mongolian
Champion, Former National
Rugby Team Player
Mr. AMARTUVSHIN KHUUKHENKHUU

BOJANGLES Grill Restaurant & Bar

at 6:00 pm

20,000 MNT PER PERSON

PRICE INCLUDES ROASTED PIG, 1 BEER and OPPORTUNITY
TO GET INVOLVED IN AUCTIONS



Bojangles Grill
restaurant & pub



Shangri-La hotel
LEARNBAWME



MICC

Зураг 58. Хандивын арга хэмжээний сурталчилгаа

Монголын "Get Into Rugby" хөтөлбөртэй танилцлаа

Дэлхийн Рагбигийн Холбооны төсөл болох Get Into Rugby буюу рагбид оролцох хөтөлбөрийн Ази Тивийн Менежер Бен Ван Рүүен Монголд ирэх хугацаандаа хөтөлбөрийн хэрэгжилт мөн цаашид хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой сургуулиудтай очиж танилцлаа. Мөн үеэр Дэлхийн Рагбигийн Холбооны эмэгтэйчүүдийн рагбигийн ерөнхий менежер, Ази болон Японы Рагбигийн Холбооны төслийн менежерүүд Эрдэм хүүхдийн асрамжийн төв багачууд дээр очиж тус төвийн хэрэгжүүлж буй ажлууд, хүүхэд багачуудтай танилцсан билээ.



Зураг 59. Эрдэм төвийн хүүхэд багачуудтай

Хүүхэд багачууд маш идэвхтэй дуртай оролцож буй энэхүү хөтөлбөр нь рагбиг анхлан суралцагч нарт аюулгүй, хөгжөөнт тоглоом байдлаар таниулах цаашид сонирхол, хүсэлтэй хүүхэд залуучуудад гүнзгийрүүлсэн шатанд оролцох боломжийг олгодоггоороо онцлог бөгөөд Ази тив 2019 он гэхэд энэхүү хөтөлбөрийн дагуу 1 сая оролцогч нарыг хамруулах зорилго тавин ажиллаж байна.



Зураг 60. Буянт-Ухаа цогцолбор сургуулийн рагбигийн бэлтгэлд 120 гаруй багачууд орлоо



Зураг 61. Рагбигийн 5 зарчмын нэг ХҮНДЛЭЛ-ийг харуулж чадсан 107-р сургуулийн охид

Рагбид оролцох нь хөтөлбөрийн Ази Тивийн Менежер Бен Ван Рүүен нийслэлийн ЕБС-ийн 107 дугаар сургууль, Бүянт-Ухаа цогцолбор сургууль, Амгалан цогцолбор сургууль, Бритиш сургууль болон Сонгинохайрхан дүүргийн Эрдэм төвийн хүүхдийн асрамжийн газарт зочилж танилцлаа.



Зураг 62. Дэлхийн Рагби болон Азийн Рагбигийн холбооны зочид Эрдэм төвийн багачуудад Хүүхдийн баярын бэлэг гардууллаа

Их Британий элчин сайдын яамнаас зохион байгуулсан “Inspire me 2017” арга хэмжээнд рагбигийн спортыг танилцууллаа

Их Британий элчин сайдын яамнаас зохион байгуулсан “Inspire me 2017” арга хэмжээнд оролцож рагбигийн спортыг Гэрэлт гудамжинд амарч байгаа зочид төлөөлөгч нарт сурталчиллаа.

Рагбигийн спортыг танилцуулах тус арга хэмжээнд Монгол улсад Англи улсаас суух элчин сайд өөрийн биеэр оролцсон бөгөөд цаашид хамтран ажиллахаа илэрхийлсэн билээ.



Зураг 63. Англи улсаас Монгол улсад суух элчин сайд Катрин Арнолд, рагбигийн тамирчдын хамт

Улаанбаатарын Олон Улсын Сургуультай хамтран рагбигийн хичээлийг зааж эхэллээ

Монголын Рагбигийн Холбоо нь Улаанбаатарын Олон Улсын Сургуультай хамтран ажиллаж байгаа бөгөөд 2017-2018 оны хичээлийн улиралд тус сургуулийн баг, дунд насны сурагчдад зориулж рагбигийн спортын сургалтыг эхлүүлсэн бөгөөд ирэх улирлаас 2 ээлжээр хичээллүүлэхээр зорин ажиллаж байна.



Зураг 64. Улаанбаатарын Олон Улсын Сургууль

МОНГОЛЫН РАГБИГИЙН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ ИВЭЭН ТЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГУУД



MICC

ИВЭЭН ТЭТГЭГЧ, ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛИМПИЙН ХОРОО

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР

КОРПОРЭЙТ ЗОЧИД БУУДАЛ

БОЖАНГЛЭС РЕСТОРАН

ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ